


Техникийн дадлагажигч бэлтгэх ажил Аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний тухай гарын авлага

Машин техниктэй харьцах, металл боловсруулах ажил



Гарчиг

Удиртгал	1
I Техникийн дадлагажигч бэлтгэх хөтөлбөрийн бүтэц	2
II Машин техниктэй харьцах, металл боловсруулах ажилд тохиолдох осол	5
III Хэрэгжүүлэгч байгууллагуудын авч үзвэл зохих асуудлууд	
1 Аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний тухай хуулийн заалтууд	7
2 Тусгай сургалт шаардах ажлууд, тусгай ажлууд	7
(1) Тусгай сургалт шаардах ажлууд	7
(2) Тусгай ажлууд	8
3 Аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээ	9
(1) Аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт	9
(2) Аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаа	10
(3) Ослын төрөлд нийцүүлэн авах арга хэмжээ	12
(4) Мэргэжлээс шалтгаалах өвчний эсрэг авах арга хэмжээ	15
(5) Эрүүл мэндийн үзлэг	17
(6) Ачааллын тест	18
4 Ажлын байранд осол гарсан үед	19
(1) Ажилчдад нөхөн олговор өгөх журам	19
(2) Техникийн дадлагажигч бэлтгэх сургалтыг түр зогсоох тухай журам	19
IV Хяналтын байгууллагуудын авч үзвэл зохих асуудлууд	
1 Хяналтын байгууллагуудын үүрэг	20
2 Техникийн дадлагажигч зөвлөгөө авах хүсэлт гаргасан тохиолдолд	20
3 Техникийн дадлагажигчдыг, тусламж дэмжлэг, мэдээллээр хангах	21
4 Аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ажлын байран дээрх аудит, зааварчилгаа	21
(1) Хэрэгжүүлэгч байгууллагуудтай шалгах асуудлуудын жишээнүүд	21
(2) Техникийн дадлагажигчидтай уулзан ярилцаж шалгах асуудлуудын жишээнүүд	21
V Машин техниктэй харьцах, металл боловсруулах ажилд тохиолдох осол	23

Удиртгал

Техникийн дадлагажигч бэлтгэх хөтөлбөрийн зорилго нь дадлагажигчдыг Япон улсад ирж эзэмшсэн ур чадвараа эргээд эх орондоо авчирч хэрэгжүүлэхэд оршино.

Мэдээж хэрэг дадлагажигчид сургалтаа осол бэртэлгүйгээр амжилттай гүйцэтгэж эх орондоо эсэн мэнд эргэж ирэх нь туйлын чухал юм.

Тиймээс хэрэгжүүлэгч байгууллагууд нь дадлагажигчдын ажлын аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахуйц арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж сургалтыг тухайн ажлын орчин болон ажлын төрөлд нийцүүлэн аюулгүй нөхцөлд явагдуулахыг хичээх ёстой.

Түүнчлэн хяналтын байгууллагууд нь хэрэгжүүлэгч байгууллагуудад ажлын байранд осол гарахаас урьдчилан сэргийлэн, сургалтыг аюулгүй явагдуулах ажлын орчныг бие даан бий болгох тал дээр зааварчилгаа, тусламж дэмжлэг өгөх үүрэгтэй.

Энэ утгаараа Техникийн дадлагажигч бэлтгэх хөтөлбөрт оролцогч талуудын хувьд хэрэгжүүлэгч байгууллагууд болон хяналтын байгууллагууд нь аюулгүй байдал ба эрүүл ахуйн стандартуудыг холбогдох хууль тогтоомжийн дагуу дээшлүүлэх үүрэгтэй юм.

Тус гарын авлагад төмөр, металл боловсруулах ажилд аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг хангах үүрэг бүхий хэрэгжүүлэгч байгууллагууд болон хяналтын байгууллагуудын хийх алхамуудыг оруулав.


Бүх хэрэгжүүлэгч байгууллагууд тус гарын авлагыг өдөр тутмын үйл ажиллагаандаа аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулахын тулд ашиглана гэдэгт бид найдаж байна. Мөн хяналтын байгууллагууд энэхүү гарын авлагыг хамаа бүхий хэрэгжүүлэгч байгууллагууддаа аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг сайжруулах, эдгээртэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад ашиглана гэдэгт найдаж байна.

I Техникийн дадлагажигч бэлтгэх хөтөлбөрийн бүтэц

Техникийн дадлагажигч бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд 3 жилийн техникийн дадлагаас гадна (i) дадлагажигчид үндсэн ур чадварыг үр дүнтэй эзэмших техникийн дадлага дээр (ii) хэрэглээний ур чадвар эзэмших нэмэлт 2 жилийн дадлага (iii) нэмж нийт 5 жилийн техникийн дадлага(*) хийх боломжтой.

* Хөнгөн цагаан ороох, металл шахаж хэвэнд оруулах ажил нь техникийн дадлагажигч бэлтгэх сургалтад үл хамаарна (iii).

◆Техникийн дадлагажигч бэлтгэх үйл явц



◆ Машин техниктэй харьцах, металл боловсруулах ажлын ангилал, үйл ажиллагаа

Техникийн дадлагажигч бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд одоогоор 91 ажлын ангилал, 167 үйл ажиллагааг (Техникийн дадлагажигч бэлтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх дүрэм журам - Хүснэгт II) техникийн дадлагажигч бэлтгэх ажилд (ii) оруулсан байгаа.

Эдгээрээс 17 ажлын ангилал, 34 үйл ажиллагааг машин техниктэй харьцах, металл боловсруулах ажилд оруулсныг доорх хүснэгтэд харуулав. Тус гарын авлагад эдгээрээс гадна 18 ажлын ангилал, 36 үйл ажиллагаанд аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний талаарх тайлбарыг багтаасан бөгөөд үүнд барилгын ажил (ажлын ангилал тус бүрт 2 үйл ажиллагаа) -ыг “машин техниктэй харьцах, металл боловсруулах ажил” гэж оруулав.

Машин техниктэй харьцах, металл боловсруулах ажил (17 ажлын төрөл, 34 үйл ажиллагаа багтсан)

[2024 оны 9-р сарын 30-ны байдлаар]

Ангилал	Үйл ажиллагаа	Ангилал	Үйл ажиллагаа
Цутгах	Төмөр цутгах үйл ажиллагаа	Машин техникийн үзлэг	Машин техникийн үзлэгийн ажил
	Төмөрлөг бус металл цутгах үйл ажиллагаа	Машин техникийн засвар үйлчилгээ	Машин техникийн засвар үйлчилгээний ажил
Давтах	Алхаар давтах үйл ажиллагаа	Электроник төхөөрөмж угсралт	Цахилгаан төхөөрөмж угсрах ажил
	Шахагч машин дээр давтах үйл ажиллагаа	Цахилгаан төхөөрөмж угсралт	Цахилгаан машин угсрах ажил
Даралтын дор цутгах	Халуун камерт даралтын дор цутгах ажил		Трансформатор угсрах ажил
	Хүйтэн камерт даралтын дор цутгах ажил		Хяналтын самбар, түгээлтийн самбар угсрах ажил
Машин техник	Хөдөлгүүрийн токарийн үйл ажиллагаа		Нээх хаах удирдлагын төхөөрөмж угсрах ажил
	Зүсэж зорох суурь машин дээрх үйл ажиллагаа		Цахилгаан кабел ороох дамар
	Токарийн ажлын тоон хяналтын үйл ажиллагаа	Электрон хавтангийн үйлдвэрлэл	Электрон хавтангийн самбарын дизайн
	Машин техникийн төв үйл ажиллагаа		Электрон хавтангийн самбар үйлдвэрлэлт
Металл шахагч	Металл дарж хэвэнд оруулах үйл ажиллагаа	Хөнгөн цагаан ороох, металл шахаж хэвэнд оруулах ●△	Зураг төслийн ажил
Төмрийн ажил	Ган боловсруулах үйл ажиллагаа		Гүйцэтгэн боловсруулах ажил
Үйлдвэрийн нимгэн металл боловсруулах ажил	Машин техникийн нимгэн металл боловсруулах үйл ажиллагаа	Металлыг илчээр боловсруулах ●	Металл бөөнөөр боловсруулах ажил
Электролизийн бүрэлт	Цахилгаанаар бүрэх ажил		Гадаргууг илчээр боловсруулах (нүүрсжүүлэх, нүүрстөрөгчжүүлэх, азотжуулах) ажил
	Хайлмал цайр бүрэх ажил		
Хөнгөн цагаан аноджуулах	Анодын исэлдэлт боловсруулах ажил		Хагас ичлээр боловсруулах (индукцийн илч, дөлөөр боловсруулах) ажил
Гүйцэтгэн боловсруулах	Гүйцэтгэн боловсруулахад ашиглах хайлуулах төхөөрөмж		
	Металлыг хэвэнд оруулах гүйцэтгэн боловсруулах ажил	* ●: Техникийн дадлагажигч бэлтгэх ажилд хийх үнэлгээтэй холбоотой ажлын ангиллууд △: Техникийн дадлагажигч бэлтгэх ажилд үл хамаарах ажлын ангиллууд (iii)	
	Машин угсрах гүйцэтгэн боловсруулах ажил		

Барилгын ажил (22 ажлын ангилал, 33 үйл ажиллагаанаас гаргаж авсан)

Ангилал	Үйл ажиллагаа
Нимгэн металл боловсруулах ажил	Агааржуулах хоолойн нимгэн металл боловсруулах үйл ажиллагаа
	Дотор, гадна нимгэн металл боловсруулах үйл ажиллагаа

Машин техниктэй харьцах, металл боловсруулах ажилд тохиолдох осол (техникийн дадлагажигчдаас өөр бусад ажилчдыг оруулан.)

Доорх хүснэгтэд ган боловсруулалт, төмөрлөг бус металл боловсруулалт, металл бүтээгдэхүүн, ерөнхий машин тоног төхөөрөмж, электрон машин тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгсэл үйлдвэрлэх ажлуудын хүрээнд машин техниктэй харьцах болон металл боловсруулах ажилд тохиолдсон ослуудыг амь насаар эндэгдсэн ослууд болон ажилчин ажлаасаа 4 буюу илүү хоногоор чөлөө авсан (цаашид “эндэгдэл, бэртэл гэмтэл учруулсан ослууд” гэх) ослуудаар тус тус хуваан ангилсан болно.

2023 онд гангийн аж үйлдвэрт нийт 9853 осол гарснаас 56 нь амь насаар эндэгдсэн тохиолдлууд байв. Эдгээр тоо баримтад сүүлийн 5 жилд орсон өөрчлөлтүүдийг доорх хүснэгтэд харуулав.

Гангийн аж үйлдвэрт гарсан ослууд

(тохиолдлууд)

	2019	2020	2021	2022	2023
Эндэгдэл	57	64	64	49	56
Эндэгдсэн эсвэл бэртэж гэмтсэн тохиолдлууд	9,838	8,777	9,534	9,771	9,853

Эх сурвалж: “Аж үйлдвэрийн ослын статус” (зөвхөн япон хувилбар), Эрүүл мэндийн яам, хөдөлмөр, нийгмийн халамжийн вэб сайтаас.

<https://www.mhlw.go.jp/bunya/roudoukijun/anzeneisei11/rousai-hassei/>

*COVID-19 цар тахалаас үүдэлтэй ослуудыг 2020 оны тоо баримтад эс оруулав.

2023 онд гангийн аж үйлдвэрт эндэгдсэн эсвэл бэртэж гэмтсэн тохиолдлуудыг ослын төрлөөр ангилахад “объект дотор эсвэл хоёр объектын завсар тээглэсэн” тохиолдлууд 2593, “унаж бэртсэн” тохиолдлууд 1538 байв.

“Объект дотор эсвэл хоёр объектын завсар тээглэсэн” болон “унаж бэртсэн” тохиолдлууд нийлээд 4131 болох бөгөөд нийт хэмжээний 41.9% эзэлж байна. Хэрэгжүүлэгч байгууллагууд болон техникийн дадлагажигчид ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг нарийн нягт хэрэгжүүлж осол үүсэх магадлалыг мэддэг байвал шаардлагатай.

Эндэгдлийг ослын шалтгаанаар харуулсан нь (2023)

(хүмүүс)

	Өндрөөс унасан	Унасан	Мөргөлдсөн	Шилдсэн эсвэл дээрээс унасан объект(ид) цохилсан	Нуралт	Мөргөлдсөн	Объект дотор эсвэл хоёр объектын завсар тээлсэн	Эзгэсэн, шалбарсан	Хадгас, шилний хэлтэрхий дээр гишгэсэн	Живсэн	Өндөр/бага температуртай объект(ид)д хүрсэн	Хорт бодист хүрсэн	Цахилгаанд цохилтосон	Тэсэрг дэлбэрсэн	Задарсан	Гал түймэр	Зам тээврийн осол (зам)	Зам тээврийн осол (бусад)	Хөдөлгөөн/эхийсүй хөдөлгөөний харуулдсан	Бусад	Ангилалдаггүй	Нийт
Бүх аж үйлдвэрүүд	204	36	7	43	38	47	108	3	0	26	35	9	6	5	1	3	148	5	0	28	3	755
Аж үйлдвэр	21	5	0	9	10	8	50	0	0	4	7	3	0	3	1	1	9	1	0	5	1	138
Гангийн аж үйлдвэр	1	0	0	0	0	1	5	0	0	0	0	0	0	0	0	1	1	0	0	1	0	10
Төмөр, ган үйлдвэрлэлт	1	0	0	0	0	0	2	0	0	0	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	4
Металл цутгах үйлдвэр	0	0	0	0	0	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	0	3
Гангийн бусад аж үйлдвэр	0	0	0	0	0	0	2	0	0	0	0	0	0	0	0	0	1	0	0	0	0	3
Төмөрлөг бус металлын аж үйлдвэр	0	0	0	0	0	0	2	0	0	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	3
Төмөрлөг бус материал боловсруулах, ороох	0	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	2
Төмөрлөг бус металл цутгах аж үйлдвэр	0	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1
Бусад төмөрлөг бус металл	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Металл бүтээгдэхүүн	2	2	0	2	3	1	7	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	1	1	20
Сав суулга, халбага сэрээ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Эрэг шураг зэргийн үйлдвэрлэлт	0	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1
Металл дарж хэвэнд оруулах ажил	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	2
Металлаар бүрэх аж үйлдвэр	0	0	0	0	0	0	2	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	3
Бусад металл	2	1	0	2	3	1	4	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	0	14
Ерөнхий машин тоног төхөөрөмж	0	0	0	0	0	1	4	0	0	0	1	0	0	0	0	0	1	0	0	0	0	7
Машин, тоног төхөөрөмж үйлдвэрлэлт	0	0	0	0	0	1	4	0	0	0	1	0	0	0	0	0	1	0	0	0	0	7
Хэмжих, жинлэх тоног төхөөрөмж	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дурангийн аппарат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Гарын цаг үйлдвэрлэлт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Нарийн ажилбарын бусад машин техник	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Цахилгаан машин тоног төхөөрөмж	1	0	0	1	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	3
Хүнд оворын цахилгаан машин техник	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1
Цахилгаан бараа үйлдвэрлэлт	0	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1
Электроник, харилцаа холбооны тоног төхөөрөмж	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад цахилгаан машин техник	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1
Тээврийн хэрэгсэл үйлдвэрлэлт	3	0	0	1	1	0	2	0	0	2	0	1	0	1	0	0	1	1	0	0	0	13
Хөлөг онгоц үйлдвэрлэлт	2	0	0	1	0	0	0	0	0	2	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	6
Автомашин үйлдвэрлэлт	1	0	0	0	1	0	2	0	0	0	0	1	0	0	0	0	1	1	0	0	0	7
Төмөр замын тээврийн автомашин	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад тээврийн хэрэгсэл	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

*Тус гарын авлагад Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (1972 оны 57-р хууль)-ийг “Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль” гэж, “Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай тогтоол” (Хөдөлмөрийн яамны 1972 оны 32 дугаар тогтоол)-ыг “Аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай тогтоол” гэж тус тус заасан болно.

1

Аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний тухай хуулийн заалтууд

Ажилчид хариуцан ажиллуулдаг компаниуд нь аж үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэхийн тулд холбогдох хууль тогтоомжийн дагуу Аюулгүй байдал ба эрүүл ахуйн тухай хууль зэрэг аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээ авах шаардлагатай байдаг. Техникийн дадлагажигчид Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд “ажилчид”-д тооцогддог учраас бүх хэрэгжүүлэгч байгууллагууд ч бас аюулгүй байдал ба эрүүл ахуйтай холбоотой хууль тогтоомжийг сахих үүрэгтэй юм.

Тиймээс хэрэгжүүлэгч байгууллагууд нь техникийн дадлагажигчдын хүлээн авсан ажил үүрэгт тулгуурлан ямар арга хэмжээ авахыг шийдвэрлэвэл зохино. Тус гарын авлагад энэ сэдвийн талаар үндсэн ойлголтыг оруулав.

Аюулгүй байдал ба эрүүл ахуйн арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Эрүүл мэндийн яам, хөдөлмөр, нийгмийн халамжийн вэб сайт дахь “Ажлын байрны аюулгүй байдлын вэб сайт” руу орно уу (https://anzeninfo.mhlw.go.jp/yougo/yougo52_1.html).

2

Тусгай сургалт шаардах ажлууд, тусгай ажлууд

(1) Тусгай сургалт шаардах ажил (Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 59-р зүйл, (3) дахь хэсэг)

Техникийн дадлагажигчдад (ажилчид) аюул, эрсдэлтэй ажил даалган өгсөн бол тэднийг эрүүл ахуй, аюулгүй байдлын тусгай сургалтад хамрагдуулах шаардлагатай. Сургалтыг засаг захиргааны нэгжид бүртгэлтэй сургалтын тусгай агентлагууд явуулна.


Хэрэв байгууллагад тухайн ажил үүрэгт хангалттай мэдлэг, ур чадвар бүхий хүн байгаа бол сургагчаар томилон сургалтыг дотооддоо явагдуулах боломжтой.

Тусгай сургалт шаардах ажлуудаас энд машин техниктэй харьцах, металл боловсруулах ажил ажлуудыг загсаав. Дэлгэрэнгүй мэдээллийг Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр ба нийгмийн халамжийн вэб сайт дахь “Лиценз, мэргэшил, ур чадвар дээшлүүлэх сургалт, аж үйлдвэрийн аюулгүй байдал ба эрүүл ахуйн тусгай сургалт” хэсгээс харна уу (зөвхөн япон хувилбар) (https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/roudoukijun/anzeneisei10/qualification_education.html).


○ Бэлүүдэх дугуйг солих, эсвэл солих үед туршиж үзэх

○ Нуман гагнуурын төхөөрөмжөөр металлыг гагнах, зүсэх ажил

○ Шахагч машины хэв гаргагчийг тохируулах, салгах, таалуулах ажил эсвэл хяргах машины ир, хамгаалалтын нээлхийг угсрах, салгах, тохируулах ажил



Өнгөлөгч суурь машин



Өнцгийн өнгөлгөөний машин

○ Даацын дээд хэмжээ(*) 1 тонноос үл хэтрэх сэрээт өргөгч ажиллуулах а


* Хамгийн дээд ачаалал гэдэг нь сэрээт өргөгчийн бүтэц, материалаас хамааран жишигт заасан ачаалж болох хамгийн дээд жинг хэлнэ. Хамгийн дээд ачааллыг сэрээт өргөгчийн пайз шошгоос харна уу.



○ 0.5 тонноос 5 тонн хүртэл өргөх хүчин чадалтай(*) кран

* Өргөх хүчин чадал гэдэг нь краны өргөж чадах хамгийн дээд жинг хэлнэ. Өргөх хүчин чадалд дэгээ зэрэг бусад эд ангиуд багтсан болно.

○ 0.5 тонноос 1 тонн хүртэл өргөх хүчин чадалтай кран, зөөврийн кран, өргөх кран дээр ажиллах




○ Хүчил төрөгч багатай орчинд ажиллах үед үүсч болох аюул

○ Тоос, тоосонцортой нөхцөлд ажиллах (хүний эрүүл мэндэд хор хөнөөлтэй асбест зэрэг бусад бодис)


(2) Тусгай ажлууд (Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 61 дүгээр зүйл, Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжүүлэх тогтоолын 20-р зүйл)

Техникийн дадлагажигч тусгай ажил (Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд аюул хөнөөлтэй хэмээн тодорхойлсон) хийх бол ур чадварын сургалтад явж тусгай зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

○ 5 тонн ба үүнээс дээш өргөх хүчин чадалтай зөөдөг кран (ачааг нэг цэгээс нөгөө цэг рүү шилжүүлэн зөөдөг жижиг кран) ажиллуулах ажил → Зөөдөг кран дээр ажиллах ур чадвар олгох сургалтанд хамрагдах ёстой



○ 1 тонноос 5 тонн хүртэл өргөх хүчин чадалтай зөөврийн кран → Зөөврийн кран дээр ажиллах ур чадвар олгох сургалтанд хамрагдах ёстой



○ 1 тонн ба үүнээс илүү өргөх хүчин чадалтай кран, зөөврийн кран, өргөх кран → Татлагат кран дээр ажиллах ур чадвар олгох сургалтанд хамрагдах ёстой

○ Шатамхай хий, хүчилтөрөгч ашиглан металл гагнах, зүсэх, халаах ажил → Хийн гагнуурын ур чадварын сургалтанд хамрагдах ёстой.

○ Хамгийн ихдээ 1 тонн ба үүнээс илүү даацтай сэрээт өргөгч ажиллуулах ажил

→ Сэрээт өргөгчийн ур чадварын сургалтанд хамрагдах ёстой



(1) Аюулгүй байдал ба эрүүл ахуйн сургалт

Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасны дагуу хэргжүүлэгч байгууллагууд техникийн дадлагажигчийг сургалтад авахдаа эсвэл дадлагажигчийн ажлын төрөлд өөрчлөлт орсон бол машин техник, түүхий материалтай хэрхэн харьцах тал дээр сургалт явуулах шаардлагатай.

Түүнчлэн Аюулгүй байдал ба эрүүл ахуйн тогтоолын 36 дугаар зүйлд заасны дагуу дадлагажигчаас аюул эрсдэлтэй ажил хийхийг шаардах бол тусгай сургалтад хамрагдуулах шаардлагатай (дээрх 2-р хэсгийг харна уу).

Техникийн дадлагажигчдын аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт.

1 Бодит жишээн дээр тайлбарлах

Ажлын байранд тохиолдсон ослууд болон үхлээс ам мөлтөс зайлсан бодит тохиолдлуудыг жишээ болгон үзүүлэх нь техникийн дадлагажигчдыг тухайн ажил үүргийг хийх явцад үүсч болох аюул эрсдлийн талаар ойлголттой болоход тус дэм болох юм.

Тухайлбал металл боловсруулах ажилд дадлагажигчид шахагч машин дээр ажиллах шаардлага гардаг. Ийм төрлийн машин дээр ажиллаж сураагүй, эсвэл анхаарал болгоомжгүй байх нь ноцтой осол гарахад хүргэдэг. Хэрэв биеийн аль нэг хэсэг машины эд ангид санамсаргүй тээглэж, орооцолдвол амь насаар эндэгдэж, гар хөлөө авахуулах өндөр эрсдэлтэй.

Ийм төрлийн осол гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд өмнө нь тохиолдож байсан ослуудын бодит жишээнүүд (жишээлбэл Эрүүл мэндийн яам, хөдөлмөр, нийгмийн халамжаас нийтэлсэн “Ажлын байрын аюулгүй байдлын вэб сайт”-д жагсаасан ослууд) дээр тайлбарлан үзүүлэх нь үр дүнтэй байдаг.

2 Зориулалтын хувцас өмсөх

Дадлагажигчдад харьцаж буй машин техник, материалтай холбоотой аюул эрсдлийг сайтар ойлгуулж, тухайн аюулаас хамгаалах зориулалтын хувцас өмсүүлэх нь чухал.

3 Ажлын журмыг бататгах

Ажлын журмыг урьдчилан тодорхойлж, дадлагажигчдад ажлын журмын талаар хангалттай ойлгуулах шаардлагатай. Мөн хэвийн ажлаас (байнгын) гадна машин техникт алдаа гарахад хийх ажил зэрэг хэвийн ажлаас өөр (байнгын бус) ажлуудыг тодорхойлох шаардлагатай.

Тухайлбал дадлагажигчид машин техникт ямар нэгэн алдаа гарсан гэж үзвэл тэдэнд дараах алхамуудыг дагөн мөрдөхийг тайлбарлаж өгөх шаардлагатай.

- Машиныг зогсоох.
- Үзлэг хийх хариуцлагатай хүнийг дуудах.
- Үзлэг хийх хүн ирэхийг хүлээх.

Дээрх ажлын журмыг бичгээр япон хэлээр болон дадлагажигчийн эх хэлээр гаргаж, дадлагажигчдад ажлын журмыг сайтар ойлгуулахын зэрэгцээ ажлын журмыг өдөр тутам системтэйгээр шалгах процессыг тодорхойлж өгөх ёстой.

4 Эх хэлээр нь тайлбарлаж өгөх

Дадлагажигчид гадаадын иргэд учраас ❶ ээс ❸ -т тодорхойлсон алхамуудыг дадлагажигчдад аль болох ойлгомжтой болгохын үүднээс эх хэл дээр нь тайлбарлаж өгвөл зохино.

Хэл ярианаас гадна дүрс, зураг ашиглах. Дүрс, зураг ашиглах нь дадлагажигчдад тайлбарлаж буй зүйлийг ойлгоход илүү хялбар болгодог.

Танхимын сургалтаас гадна бас ажлын байран дахь практик сургалт OJT (on the job training) явуулж машин техниктэй хэрхэн харьцах, ямар арга хэмжээ авах тал дээр тайлбарлан үзүүлэх нь үр дүнтэй байдаг. Тиймээс OJT (on the job training) буюу ажлын байран дахь сургалт явуулж дадлагажигчийн ойлголтын түвшинг шалгаж байх нь чухал.

Эрүүл мэндийн яам, хөдөлмөр, нийгмийн халамжийн вэб сайт дахь “Гадаадын ажилчдад зориулсан Аж үйлдвэрийн аюулгүй байдал ба эрүүл ахуйн талаарх сургалтын материалууд” (зөвхөн япон хувилбар) хэсэг рүү орж видео сургалтын материалууд олж авах боломжтой. Эдгээр видеонуудыг үзэж ашиглана уу.

<https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/0000186714.html>

(2) Аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаа

Тус хэсэгт аж үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх талаар үр дүнтэй аргачлалыг танилцуулна. Эдгээрийг заавал даган мөрдөнө үү.

1 5S

5S гэдэг нь Seiri (ялгаж салгах), Seiton (эмхлэн цэгцлэх), Seisou (цэвэрлэх), Seiketsu (жигдрүүлэх) ба Shitsuke (тогтворжуулах) хэмээх 5 үгийн эхний 5 үсэг болно.

5S-ийг өдөр тутам биелүүлэх нь ажлын байранд бэртэж гэмтэхээс урьдчилан сэргийлэхэд чухал юм.

[Seiri (ялгаж салгах)]

Хэрэггүй зүйлсийг эмх замбараагүй орхих нь тээглэж, унаж бэртгэх аюултай. Хэрэггүй зүйлсийг хэрэгтэй зүйлсээс ялгаж салга.



[Seiton (эмхлэн цэгцлэх)]

Техникийн дадлагажигч бэлтгэх ажилд ямар багаж хэрэгсэл ашиглах болон эдгээрийг хаана байрлуулахыг шийдвэрлэх. Багаж хэрэгслийг эмх замбараагүй тавих нь дараа олоход хэцүү болгож, улмаар ажлын бүтээмжийг бууруулдаг.


[Seisou (цэвэрлэх)]

Техникийн дадлагажигч бэлтгэх ажлын талбар, тоног төхөөрөмжийг үргэлж цэвэрхэн байлга. Жишээлбэл шалыг цэвэрлэхгүй үлдээх нь халтирч бэртэж гэмтэх эрсдэлтэй.



[Seiketsu (жигдрүүлэх)]

Seiri, seiton болон seiso-г хэрэгжүүлсэн бол ажлын орчныг илүү таатай байлгах схем гарга.



[Shitsuke (тогтворжуулах)]

4S (seiri, seiton, seiso болон seiketsu)-г хэрэгжүүлэх ажлын журмыг гаргаж хүн бүрийн аюулгүй байлдыг хангасан орчныг бий болгохын тулд хамтдаа хичээн зүтгэ.

2 Эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь ажлын байранд бэртэж гэмтэхээс урьдчилан сэргийлэх зорилготой юм. Ажилчид илүү сонор сэрэмжтэй ажиллахын тулд эрсдэл, бэртэл гэмтлийн талаар ярилцаж санаа бодлоо хуваалцах нь чухал. Ийм төрлийн үйл ажиллагааг “КҮ үйл ажиллагаа” буюу “КҮК” гэх бөгөөд, Kiken Yochi Katsudou (эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа) гэх гурван үгийн эхний үсэг болно.

Эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хэд хэдэн аргачлал байдаг. Доор а-гаас d хүртэлх аргачлалыг харуулсан бөгөөд эдгээрийг техникийн дадлагажигчидтай хамт туршиж үзнэ үү.

a. Тухайн нөхцөл байдлыг ойлгох

Ажилчид ажлын байран дахь болзошгүй аюултай холбоотой асуудлуудыг авч үзнэ. Хэд хэдэн ажилчид бусад ажилчдад шүүмжлэгдэхгүйгээр аль болох олон асуудлыг илрүүлж нэг ч асуудлыг орхигдуулахгүй байх хэрэгтэй.

b. Асуудлын мөн чанарыг олж илрүүлэх

Ажилчид асуудлыг илрүүлсэн бол хамтдаа хянан шалгалт хийж шалтгааныг нь олж мэдээд ямар арга хэмжээ авах тухай шийдвэрлэнэ.

c. Санаачилга гаргах

Ажилчид асуудлыг шийдвэрлэх, сайжруулах тал дээр санаачилга сүвэгчлэхийг хөхүүлэн дэмжих.

d. Зорилт тавих

Асуудлыг шийдвэрлэх, сайжруулах талаар хэлэлцэж, хийх алхамуудын талаар тохиролцоонд хүрсэн бол товч тойм гаргана.

3 Эрсдлийн удирдлага

Эрсдлийн удирдлага гэдэг нь ажлын байранд гарч болзошгүй “аюул, эрсдлийг” илрүүлж эдгээрийг ноцтой байдлаар нь ангилаад, зайлсхийх эсвэл бууруулах аргачлалыг хэлнэ. Ингэснээр ажлын байранд осол гарахаас урьдчилан сэргийлэхээс гадна гарч болзошгүй ослын ноцтой байдлыг багасгах юм. Журмыг доор а-гаас с алхамуудаар харуулав.

a. Аюул эрсдлийг илрүүлэх

Аливаа аюул эрсдлийг илрүүлэх. Энэ алхамыг олон хүний өнцгөөс харвал хамгийн үр дүнтэй.

b. Эрсдлийг үнэлэх

Аюул эрсдэлтэй хэмээн тодорхойлсон объектуудыг үүсч болох магадлал болон ноцтой байдлаар нь үнэлгээ хийх.

c. Эрсдлийг бууруулах

Хийсэн үнэлгээний үр дүнд тулгуурлан өндөр эрсдэлтэй объектуудын эрсдлийг бууруулах арга хэмжээг гаргаж, хэрэгжүүлэх. Бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсний дараа эрсдэлд дахин үнэлгээ хийж нэмэлт арга хэмжээ шаардлагатай эсэхийг авч үзнэ.

(3) Ослын төрөлд нийцүүлэн авах арга хэмжээ

1 Объект дотор эсвэл хоёр объектын завсар тээглэсэн

Машин техниктэй харьцах, металл боловсруулах ажил дээр “объект дотор эсвэл хоёр объектын завсар тээглэсэн” осол хамгийн түгээмэл тохиолддог тул хэрэгжүүлэгч байгууллагууд болон техникийн дадлагажигчид ийм төрлийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах ёстой.


Нэгдүгээрт, зориулалтын хувцас өмсөх нь ийм төрлийн ослоос урьдчилан сэргийлэх нэг арга хэмжээ юм. Жишээлбэл ажилчин машин дээр ажиллаж байхдаа цамцны ханцуйгаа эд ангид тээглүүлж оруулах нь ноцтой гэмтэл үүсгэж болзошгүй юм. Тиймээс зориулалтын ажлын хувцас, хамгаалалтын хэрэгсэл ашиглах ёстой.

Ослоос урьдчилан сэргийлэх аюулгүй байдлын тоног төхөөрөмж суулгах. Аюулгүй байдлын тоног төхөөрөмжид дараах багтаж болно. Дадлагажигчид эдгээр тоног төхөөрөмжийг хэрхэн суулгахаас гадна бас хэвийн ажиллагааг нь тогтмол хянаж эдгээр тоног төхөөрөмжийг бүрэн гүйцэт ашиглаж байх тал дээр зааж өгнө үү.


a. Хамгаалалт

Хашилт, таглаа зэрэг хамгаалалтын хэрэгсэл суулгах нь ослоос урьдчилан сэргийлэхэд нэмэртэй байх болно.

[Хамгаалалтын хашаа]




[Хамгаалалтын таглаа]



b. Илрүүлэлт, хамгаалалтын төхөөрөмж

Хүн ойртоход машиныг автоматаар зогсоодог мэдрэгч зэрэг хамгаалалтын төхөөрөмж суулгах нь ослоос урьдчилан сэргийлэхэд ач тустай юм.



c. Хоёр гараар ажиллуулдаг төхөөрөмж

Хоёр унтраалгатай учраас унтраалгыг хоёр гараараа ажиллуулан машиныг асаах зориулалттай төхөөрөмж.

Ийм төхөөрөмж нь ажилчныг хоёр гараа тодорхой байрлалд хөдөлгөөнгүй байрлуулахыг шаарддаг бөгөөд гар хуруу бэртэхээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй юм.



2 Унаж бэртэх

“Объект дотор эсвэл хоёр объектын завсар тээглэсэн” ослын дараа “унаж бэртсэн” ослууд цөөнгүй тохиолддог. Тиймээс унаж бэртэх ослоос урьдчилан сэргийлэх бүрэн арга хэмжээ авах шаардлагатай юм.

Халтирч унах, бүдэрч унах, хий гишгэх нь унаж бэртэх гол шалтгаан болдог.

- Халтирч унах

Халтирдаг хулдаастай, тос, ус гоожсон шалан дээр халтирах эрсдэл өндөр байдаг.

- Бүдэрч унах

Овгор товгор гадаргуу дээр явахдаа бүдэрч унах эрсдэл өндөр байдаг. Уут, сав баглаа зэрэг энд тэнд орхисон зүйлд бүдэрч унах тохиолдлууд бас бий.

- Хий гишгэх

Жишээлбэл шатаар ачаа барин буухдаа урдхаа харахгүй хий гишгэж унах.



Унахаас урьдчилан сэргийлэхийн тулд дараах а-с алхамуудыг даган мөрдөнө үү.

а. 5S-г ягштал баримтал

Дээрх (2)①-т танилцуулсанчлан, 5S-ийг бүрэн гүйцэт хэрэгжүүлснээр “унаж бэртэх” аюулаас урьдчилан сэргийлэх боломжтой.

б. Зориулалтын гутал өмсөх

Ажлын төрөл, хүнд зүйл өргөх эсэх, ус, тостой харьцах, эсвэл шалны төрлөөс (пилта, хивс г.м.) хамааран зориулалтын гутал өмсөх нь чухал.

в. Бусад

Үйлдвэр, байгууламж дотор гараа халаасандаа хийн алхах, гүйхийг хориглохын үүднээс зохих арга хэмжээг бүрэн гүйцэт авах шаардлагатай.

3 Өндрөөс унах

2 метр ба үүнээс илүү өндөрт ажиллахдаа барилгын шат, хаалт, бариул зэрэг хамгаалалтын хэрэгслийг шалан дээр (ажиллах гадаргуу дээр) ашиглах шаардлагатай.

Хэрэв тухайн ажлын төрлөөс шалтгаалан ажлын шат, бариул босгох боломжгүй эсвэл бариулыг түр зуур салгасан бол гадаргуу дээр хамгаалалтын тор татаж, хамгаалалтын тоноглол зүүх шаардлагатай.

4 Эсгэрэх, шалбарах

Суурь машин дээр металл боловсруулах ажил хийх явцад жижиг үртэс үүсэх нь бий. Ялангуяа зэвэрдэггүй гангийн үртэс нь хутганы ир шиг хурц бөгөөд арсыг гүн эсгэх аюултай байдаг. “Эсгэрэх, шалбарахаас” урьдчилан сэргийлэхийн тулд зориулалтын бээлий өмсөнө үү.

5 Цахилгаанд цохиулах

Машин техник ихэвчлэн цахилгаанаар ажилладаг. Цахилгаан гүйдэл хүний нүдэнд үл үзэгдэх боловч аюултай бөгөөд зарим тохиолдолд амь насанд халтай гэдгийг байнга санаж явах хэрэгтэй. Цахилгаан гүйдэл нь гадны биетийг ноцоож гал түймэр гаргахаас гадна хүрсэн хүнийг цахилгаанд цохиулах аюултай.

Тиймээс дадлагажигчид цахилгаантай харьцах тал дээр зохих ойлголттой байх нь чухал. Жишээлбэл нойтон гараараа машинд хүрэхгүй байх, коридороор зорчихдоо кабел, утаст таварцаглахаас болгоомжлох, чухал бус системүүдийн бүх таслуурыг унтраасан байх зэрэг цахилгаантай харьцах журмыг тогтоох хэрэгтэй.

6 Бусад

Металл боловсруулах ажилд голдуу боловсруулах материалыг зөөх болон боловсруулж дууссан материалыг зөөх ажил гардаг. Ингэхийн тулд сэрээт өргөгч зэрэг машин ашиглаж болно.

Техникийн дадлагажигчид ийм төрлийн машин дээр бие даан ажиллах эсвэл, ийм төрлийн машины ойр хавьд ажиллах бол ослоос сэргийлэх арга хэмжээ авсан байх шаардлагатай.

- Сэрээт өргөгч

Сэрээнд өргөсөн ачаа операторын харах талбайг халхалдаг. Оператор арагшаа ухран жолоодохдоо ардаа байсан хүнийг харахгүй мөргөх тохиолдол гардаг.

Тиймээс ажлын байранд сэрээт өргөгч ашиглах бол ойр хавьд байгаа хүн бүр сэрээт өргөгчийн маршрутыг урьдчилан мэддэг байх ёстой. Маршрутын дагуу аюулгүй байдлын тэмдэг тавих нь бас үр дүнтэй байдаг.

- Кран, зөөврийн кран

Кран, зөөврийн кран ашиглах бол оператороос гадна бас ойр хавьд байгаа хүн бүр ямар ачаа өргөхийг нь урьдчилан мэддэг байх ёстой.

Краны өргөсөн ачааны доор эсвэл тэнцвэр алдагдаж хөмөрсөн краны доор дарагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд орохыг хориглосон тэмдэг тавих нь зүйтэй.

Татлагын ажил эхлэхийн өмнө кабелийн аюулгүй байдлыг шалгахын тулд эвдэрсэн утас зэрэг гэмтэл байгаа эсэхийг шалгах хэрэгтэй.

(4) Мэргэжлээс шалтгаалах өвчний эсрэг авах арга хэмжээ

1 Наршилтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Наршилт нь халуун, чийгтэй орчинд удаан ажиллахад биеийн температур нэмэгдэж улмаар биеийн дулааныг хэвийн түвшинд оруулах боломжгүй болоход үүсдэг.

Наршилтаас сэргийлэхийн тулд ажиллах орчин болон ажилчдыг тус тусд нь авч үзэх шаардлагатай юм.

Зуны улиралд салхигүй, халуун салхитай, халуун бөгчим, чийгтэй, хэт ягаан туяанаас үүссэн илч бүхий орчинд ажиллах шаардлага гарах нь бий. Чийгшил ихтэй орчинд их хэмжээгээр хөлрөхөөс гадна хөлс илүү удаан ууршрдаг. Энэ нь биеийн температурыг зохицуулахад үр дүнгүй бөгөөд улмаар шингэний дутагдалд оруулах нь бий. Тиймээс нарны хэт улаан туяанаас халхлах саравч, агааржуулалт ашиглахыг зөвлөж байна.

Ажлын хүчин зүйлст хүнд юм өргөх, олон цагаар завсарлагагүй эсвэл цөөхөн завсарлагатай ажиллах, “амьсгалдаггүй” эсвэл чийг хуримтлуулдаг хувцас, хамгаалалтын хэрэгсэлтэй ажиллах зэрэг хүчин зүйлс орно. Борооны улирлын эцэст, болон амралт дууссаны дараахан гаднах температур огцом нэмэгдэх үед ажиллах бол ойр ойрхон завсарлага авдаг байвал зүгээр. Алдсан биеийн шингэн, давс зэргийг нөхөж биеээ сэрүүцүүлэх нь чухал юм.

Наршилтын шинж тэмдгүүд тухайн хүний биеийн байдлаас шалтгаалан өөр өөр байна. Гадны температурт дасан зохицоход хэдэн өдрөөс нэг долоо хоног шаардагдах нь бий. Гадны температурт дасан зохицох хүртэл бие махбод хөлс гадагшлуулахдаа тааруухан байдаг учраас биеийн температур амархан нэмэгддэг. Биеийн температур хэвийн түвшинд ороогүй бол (жишээлбэл, нойр муутай хонсны дараа) ажлаасаа чөлөө авсан нь дээр юм. Хоол унд идэхгүйгээр удаан ажиллах нь маш аюултай байдаг. Тиймээс дадлагажигчдыг биеийнхээ байдлын талаар үнэн зөв мэдээлэл өгч, эрүүл мэндийн ямар нэгэн асуудалтай бол халуун чийгтэй орчинд ажиллуулахгүй байх, ажлын чөлөө өгч тамир тэнхээг нь нөхөх бололцоогоор хангах ёстой.

2 Нүүрстөрөгчийн дутуу ислийн хордлогын эсрэг авах арга хэмжээ

Нүүрстөрөгч агуулсан бодис агааржуулалтгүй битүү орчинд шатахад нүүрстөрөгчийн дутуу исэл үүсдэг учир нь хүчил төрөгч багатай орчинд эдгээр бодис зохих ёсоор шатах боломжгүй байдаг. Ажил дээрх хүн бүр тухайн хийх гэж буй ажил нь нүүрс төрөгчийн дутуу исэл үүсгэж болзошгүй эсэх болон нүүрс төрөгчийн дутуу ислийн шинж чанар (өнгөгүй, үнэргүй) болон хоруу чанарын талаар мэддэг байх ёстой.

Хэрэв тухайн ажил нь нүүрс төрөгчийн дутуу исэл үүсгэх магадлалтай бол цонхоо нээж яндангийн хийг гадагшлуулах, мөн агааржуулах систем, утаа илрүүлэх систем зэргийг суулгах нь зүйтэй юм.



3 Тоосноос урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Металл боловсруулах явцад үүсэх тоосноос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь чухал. Гагнуурын ажлын явцад агаарт утаа, тоос тоосонцор үүсдэг. Амьсгалахад хамраар орсон тоосны ихэнх нь эргээд хамраар гадагшилдаг. Гэхдээ зарим тоос амьсгалын замд хуримтлагдах нь бий. Хуримтлагдсан тоосыг бие организм өөрөө бага багаар цэвэрлэж гадагшлуулдаг боловч зарим тоос нь гадагшлахгүй биед үлддэг. Энэ нь улмаар үрэвсэл үүсгэж, зарим тохиолдолд пневмокониоз буюу уушгины өвчин үүсгэдэг.

Пневмокониоз нь олон жилийн турш тоос, тоосонцор, хүнд металлаар амьсгалсны улмаас уушгины эд эс фиброз болон хатуурч, уян хатан чанараа алддаг өвчин юм. Одоогийн байдлаар анагаах ухаанд пневмокониозыг эмчлэх эм байхгүй боловч шинж тэмдгийг нь багасгах боломжтой байна.

Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоолоос гадна Тоос, тоосонцроос үүдэлтэй аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай хууль тогтоол байдаг. Тоос, тоосонцроос үүдэлтэй аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай тогтоолд “тоос тоосонцортой харьцах ажил” хэмээн ангилагдсан ажил хийх бол тусгай арга хэмжээ авах шаардлагатай. Тиймээс техникийн дадлагажигчдын хүлээн авсан ажил даалгаварт “тоос тоосонцортой харьцах ажил” орсон эсэхийг шалгах хэрэгтэй.

Тоос, тоосонцортой харьцахад дараах арга хэмжээг даган мөрдөн үү.

a. Тоос аль болох бага үүсгэхийг хичээх.

Ингэхийн тулд тоос үл үүсгэдэг түүхий материал, тоос амархан үүсдэг орчинд зохих ажлын журмыг сайжруулах хэрэгтэй.

b. Үүссэн тоосыг аль болох тараахгүй байхыг хичээх.

Үүссэн тоосыг ажлын орчинд тараахгүй байхын тулд юуны өмнө тоосны эх үүсвэрийг олж илрүүлээд битүүмжлэх, тусгаарлах хэрэгтэй. Мөн доторх тоосыг гадагшлуулах яндан ашиглаж болно.

- с. Агаарт байгаа тоос хүний биед орохоос урьдчилан сэргийлэх
Ингэхийн тулд тоос гадагшлуулах агааржуулалтын систем суулгаж, тоосны маск ашиглавал зохино.



(5) Эрүүл мэндийн үзлэг

Байгууллагууд Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд зааснаар ажилчдад дараах үзлэгийг хийсэн байх шаардлагатай.

1 Эрүүл мэндийн ерөнхий үзлэг

- Ажилд элсүүлэхэд хийх үзлэг (Аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 43 дугаар зүйл)
Үзлэгийг ажилчны эрүүл мэндийн байдалд тохирсон ажил өгөхийн үүднээс хийдэг. Тус үзлэгт мөн техникийн дадлагажигчид хамрагдах ёстой бөгөөд доорх 11 үзлэгүүдийг хийх шаардлагатай. Өнгөрсөн жилүүдэд гадаадаас ирсэн хүмүүст сүрьеэ өвчин илэрсэн тохиолдлууд гарсан тул элсэлт хийх үед үзлэг хийж, дадлагажигчид сүрьеэ өвчин туссан байж болзошгүй гэдгийг анхаарна уу.

- | | |
|---|---|
| a. Эрүүл мэнд, хөдөлмөрийн түүх | g. Элэгний үйл ажиллагаа (GOT, GPT, γ-GTP-ийн шинжилгээ) |
| b. Субъектив, объектив шинж тэмдгүүд | h. Цусан дахь липидийн түвшин |
| c. Биеийн өндөр, биеийн жин, бүсэлхийн тойрог, хараа, сонсгол | i. Цусан дахь сахарын түвшин |
| d. Цээжний рентген шинжилгээ | j. Шээсний шинжилгээ (шээсэн дэх сахар, уургийн агууламж) |
| e. Цусны даралт | k. Электрокардиограммын шинжилгээ |
| f. Цус багадалтын шинжилгээ (гемоглобины агууламж ба эритроцитын шинжилгээ) | |

<Сүрьеэ өвчин илрэхэд авах хариу арга хэмжээ>

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай, өвчтөнд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасны дагуу сүрьеэгийн эсрэг хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ. Сүрьеэ өвчин илэрсэн эмнэлгийн байгууллагуудаас бусад ажлын байранд гарсан тохиолдолд сүрьеэгийн халдвар авсан эсвэл авсан байж болзошгүй хүмүүсийг түргэн шуурхай илрүүлж, хариу арга хэмжээ авахын тулд өртсөн хүнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах нь чухал.

Нийгмийн эрүүл мэндийн төвөөс ирсэн зааврын дагуу ажиллана. Хэргжүүлэгч байгууллагууд нь өртсөн ажилчдыг илрүүлж, байнгын үзлэгт ороогүй ажилчдыг үзлэгт оруулахыг шаардаж, өртсөн хүмүүсийг шуурхай үзлэгт оруулах үүрэгтэй юм.

- Эрүүл мэндийн байнгын үзлэг (Аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 44 дүгээр зүйл)

Техникийн дадлагажигчдыг хуульд заасан шаардлагын дагуу жилд нэг удаа үзлэгт оруулна уу. Доорх 11 үзлэгүүдийг хийх шаардлагатай. с, d болон f-ээс i хүртэл, бас k-г эмч хийх шаардлагагүй гэж үзвэл хасаж болно.

- Эрүүл мэнд, хөдөлмөрийн түүх
- Субъектив, объектив шинж тэмдгүүд
- Биеийн өндөр, биеийн жин, бүсэлхийн тойрог, хараа, сонсгол
- Цээжний рентген шинжилгээ, цэрний шинжилгээ
- Цусны даралт
- Цус багадалтын шинжилгээ (гемоглобины агууламж ба эритроцитын шинжилгээ)
- Элэгний үйл ажиллагаа (GOT, GPT, γ -GTP-ийн шинжилгээ)
- Цусан дахь липидийн түвшин
- Цусан дахь сахарын түвшин
- Шээсний шинжилгээ (шээсэн дэх сахар, уургийн агууламж)
- Электрокардиограммын шинжилгээ



- Тусгай ажил хийдэг хүмүүс хийлгэх эрүүл мэндийн үзлэг (Аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 45 дугаар зүйл)

Хар тугалга, нүүрстөрөгчийн дутуу исэл зэрэг хорт хий, уур, тоос, тоосонцортой орчинд байнга, ялангуяа шөнийн ээлжээр ажилладаг хүмүүс ийм төрлийн ажилд орсны дараа хийсэн үзлэгээс гадна 6 сар буюу үүнээс бага сар тутам үзлэгт орох шаардлагатай.

2 Дээр жагсааснаас өөр бусад эрүүл мэндийн үзлэгүүд (жишээнүүд)

- Эрүүл мэндийн тусгай үзлэг

Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжүүлэх тогтоолын 22-р зүйл, (1) дэх хэсэгт заасны дагуу аюултай нөхцөлд ажилладаг хүмүүс болон 22-р зүйл, (2) дахь хэсэгт заасны дагуу аюултай нөхцөлд өмнө нь ажиллаж байсан хүмүүс эрүүл мэндийн тусгай үзлэгт орох шаардлагатай.

Аюултай нөхцөлд дараах орно (1) Өндөр даралтат орчинд ажиллах, (2) Цацрагтай харьцах, (3) Ариутгалын ажил, (4) Тусгай химийн бодистой харьцах, (5) Асбесттай харьцах, (6) Хар тугалгатай харьцах, (7) Тетра-алкил хар тугалгатай харьцах, болон (8) Органик уусгагчтай харьцах.

- Пневмокониозын үзлэг

Пневмокониозын тухай хуульд зааснаар тоос тоосонцортой нөхцөлд байнга ажилладаг ажилчид болон ийм нөхцөлд өмнө нь ажиллаж байсан ажилчид эрүүл мэндийн тусгай үзлэгт орох шаардлагатай.

(6) Ачааллын тест

Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд зааснаар 50 буюу үүнээс илүү ажилчинтай байгууллагууд ажилчдаа “сэтгэлзүйн ачааллын үнэлгээ хийх үзлэг” (цаашид “ачааллын тест” гэх)-т оруулах шаардлагатай.

Тиймээс 50 буюу үүнээс илүү ажилчинтай (техникийн дадлагажигчдыг оруулан) хэрэгжүүлэгч байгууллагууд ачааллын тест хийх шаардлагатай юм.

(1) Ажилчдад нөхөн олговор өгөх журам

Техникийн дадлагажигч дадлага хийж байхдаа бэртэж гэмтвэл анхны тусламж үзүүлсний дараа нөхөн олговрын даатгалын журамд заасны дагуу эмнэлэгт хүргэж эмчилгээ хийлгэх ёстой (*1). Мөн техникийн дадлагажигч аж үйлдвэрийн ослын улмаас 4 ба үүнээс дээш хоногоор ажил таслах шаардлага гарсан(*2) бол Хөдөлмөрийн стандартын хяналтын албанд ажилчдын хохирлын тайланг ирүүлнэ үү.

*1: Дэлгэрэнгүй мэдээллийг Эрүүл мэндийн яам, хөдөлмөр, нийгмийн халамжийн вэб сайт руу орж "Гадаад ажилчдад зориулсан аж үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн даатгалын өргөдөл гаргах заавар - Гадаад ажилчдын аж үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн даатгалын тухай товхимол"-оос авна уу. (https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/koyou_roudou/roudoukijun/gyousei/rousai/gaikoku-pamphlet.html).

*2: Ажлаас 1-ээс 3 хоногийн чөлөө авахыг шаардсан бэртэл гэмтэл байвал холбогдох Хөдөлмөрийн стандартын үзлэгийн оффис руу 3 сар тутам тайлан илгээнэ үү https://anzeninfo.mhlw.go.jp/yougo/yougo29_1.html

Аж үйлдвэрийн ослоос үүдсэн бэртэл гэмтэлд эрүүл мэндийн даатгалыг ашиглах боломжгүй. Хэрэв дадлагажигч аж үйлдвэрийн осолд бэртэж гэмтсэн явдлыг нуун дарагдуулж эрүүл мэндийн даатгал ашиглан дадлагажигчийг эмчилгээнд хамрагдуулж, Ажилчдын хохирлын тайланг эс илгээвэл "аж үйлдвэрийн осол нуун дарагдуулсан" хэргээр шийтгэл оногдуулж болозшгүй гэдгийг анхаарна уу.

(2) Техникийн дадлагажигч бэлтгэх сургалтыг түр зогсоох тухай журам

Техникийн дадлагажигч ажлын байранд амь насаар эндэгдсэн золгүй тохиолдолд, эсвэл урт хугацаагаар эмчилгээ хийх болсны улмаас дадлага хийх боломжгүй болсон тохиолдолд "Техникийн дадлага хийхэд тулгарсан бэрхшээл" маягтыг ашиглан мэдэгдэл(*) илгээнэ үү.

* Хяналтын байгууллагууд нь хяналт ба зохион байгуулалтын төрлийн дадлагын тухай мэдэгдлийг, хэргжүүлэгч байгууллагууд нь хувь хүн, байгууллагын төрлийн дадлагын тухай мэдэгдлийг тус тус илгээнэ. Хэргжүүлэгч байгууллагаас явагдуулж буй хяналт ба зохион байгуулалтын төрлийн дадлагын хувьд аж үйлдвэрийн ослын талаарх мэдэгдлийг хяналтын байгууллагад илгээнэ үү.

Хэрэв дадлагажигчийн эмчилгээний курс богино бөгөөд дадлагыг үргэлжлүүлэхэд саад болох хүчин зүйлс байхгүй гэж үзвэл дээрх мэдэгдлийг илгээх шаардлагагүй.

Техникийн дадлагажигч зохих ёсоор бэлтгэн сургах, хамгаалах тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хяналт ба зохион байгуулалтын төрлийн дадлага явуулдаг хэргжүүлэгч байгууллагууд нь Хөдөлмөрийн стандартын тухай хууль, Аж үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон хөдөлмөрийн тухай бусад хуулийг эс зөрчүүлэхийн үүднээс хяналтын байгууллагууд нь хяналтын менежерийн зааврын дагуу зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрсэн бол нөхцөл байдлыг засч залруулах үүрэгтэй.

Тиймээс хяналтын байгууллагуудтай холбоо бүхий хэргжүүлэгч байгууллагууд нь холбогдох хууль журмыг зөрчихгүй байхын үүднээс тэдэнд аюулгүй байдал, эрүүл ахуйн чиг баримжаа өгөх нь чухал юм. Техникийн дадлагажигчид дадлага сургалтаа эрүүл, аюулгүй нөхцөлд хийж гүйцэтгэсэн бол тэднийг эх оронд нь эсэн мэнд буцаах тал дээр тусламж дэмжлэг өгөх хэрэгтэй.

Төлөвлөлтийн зааварчилгаа өгөх тусгай мэдлэгтэй хяналтын байгууллагуудын хувьд доор тайлбарласан зүйлүүд энгийн байж болох ч эдгээрийг дахин шалгаж, сайтар хэрэгжүүлнэ үү.

Техникийн дадлагажигч өдөр тутмын хийдэг ажил нь аюул эрсдэлтэй учраас осол гарах вий гэж айсаар ослоос урьдчилан сэргийлэх ажлын арга барил, нөхцлийг сайжруулах тал дээр хэлэлцүүлэгт оролцож санал бодлоо илэрхийлбэл, санал бодлыг нь хэргжүүлэгч байгууллагуудад илгээж нөхцөл байдлыг сайжруулах тал дээр зохих арга хэмжээ авахыг хичээх хэрэгтэй. Дадлагажигч эсвэл хэргжүүлэгч байгууллага нь хэлэлцүүлэгт хөндсөн асуудлуудыг өөрийн мэдлээр шийдвэрлэж үл болно.

Ээлжийн ажил хийдэг дадлагажигчид бие биетэйгээ уулзахгүй байдаг учраас харилцаа холбооны дутагдалд орох нь бий. Тиймээс харилцаа холбоо дутмаг талбарт тусламж дэмжлэг өгөх нь чухал юм.

Дээр дурдсан тусламж дэмжлэг өгөх хүрээнд илүү үр дүнтэй арга барил ашиглахын тулд техникийн дадлагажигчдаас ирсэн аливаа санал хүсэлтэд шуурхай хариу өгөх системийг бий болгох, мөн түүнчлэн дадлагажигчид хяналтын байгууллагуудтай эх хэлээрээ харилцах боломжийг бүрдүүлэх нь чухал юм.

Дадлагажигчид өөр хэл соёлтой учраас тэдэнтэй харилцаа холбоо тогтооход хэл нэвтрэлцэхгүй, саад бэрхшээл тулгарах нь хэвийн үзэгдэл юм. Тиймээс уугуул япон ажилчид эдгээр саад бэрхшээлийг ухааран, гадаад ажилчидтайгаа хүлцэнгүй харьцах нь чухал.

Хэргжүүлэгч байгууллагууд техникийн дадлагажигчдад хангалттай мэдээлэл өгсөн ч тэдэнд зарим зүйлс ойлгомжгүй байх нь хэвийн үзэгдэл юм.

Дадлагажигчдад наршилт, мөсөн дээр халтирах, хоол хүнсний хордлого, цахилгаанд цохиулах зэргээс урьдчилан сэрхийлэх тал дээр тусламж дэмжлэг, мэдээлэл өгөх хэрэгтэй.

Хяналтын байгууллагууд болон хэргжүүлэгч байгууллагууд нь дадлагажигчдын нөхцөл байдлыг сайтар ойлгож Япон улсад сайхан амьдрах боломжийг нь хангахын үүднээс сургалтыг аль болох ойлгомжтой байлгахыг хичээх ёстой.

Ажлын байранд зааварчилгаа, аудит хийхэд аюулгүй байдал ба эрүүл ахуйг сахих

Хяналтын байгууллагууд нь хэргжүүлэгч байгууллагуудад аюулгүй байдал ба эрүүл ахуйн тухай зааварчилгаа, тусламж дэмжлэг (техникийн дадлагажигч бэлтгэх (i) бол дор хаяж сард нэг удаа, байнгын аудит бол дор хаяж 3 сард нэг удаа) өгөх шаардлагатай.

* Тус хэсэгт аюулгүй байдал ба эрүүл ахуйн арга хэмжээний жишээнүүдийг тайлбарлав. Дадлагажигчдын цалин хөлсний хэмжээ, хүний эрхийн зөрчил, оршин суух зөвшөөрлийн картыг нь зүй бусаар хадгалах тал дээр хянан шалгах шаардлагатай.

(1) Хэргжүүлэгч байгууллагуудтай шалгах асуудлуудын жишээнүүд

- Техникийн дадлагажигчдын харилцаа холбоо дутмаг эсвэл тэдэнд хэлсэн зүйлийг эс ойлгох нөхцөл байдал үүсч байна уу?
- Дадлагажигч аюулгүй байдлын сургалтад явж зохих гэрчилгээг авсан уу?
Дадлагажигч ажилдаа нийцсэн аюулгүй байдал ба эрүүл ахуйн сургалтад хамрагдсан уу? Сэрээт өргөгч зэрэг тусгай тоног төхөөрөмж дээр ажиллахыг шаарддаг уу? (хэрэв тийм бол ур чадварын тусгай сургалтад хамрагдсан уу?)
- Ажлын зориулалтын хувцас өмсдөг үү?
Дадлагажигч ажлын аюултай бүст ажиллахдаа “толгойны хамгаалалт”, “хамгаалалтын гутал, халтирдаггүй гутал” зэргийг ашигладаг уу?
- Дадлага явагдуулж буй ажлын байр аюулгүй байдал ба эрүүл ахуйн стандартыг хангасан уу?
- Дадлагажигчийн байр орон сууц эрүүл ахуйн шаардлагыг хангасан уу?
- Ажлын байранд осол гарсан уу (үхлээс ам мөлтөс зайлсан тохиолдлуудыг оруулан)? (хэрэв тийм бол осол гарсны дараа ямар арга хэмжээ авсан болон осол дахин тохиолдохоос урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авсан бэ?)

(2) Техникийн дадлагажигчидтай уулзан ярилцаж шалгах асуудлуудын жишээнүүд

- Дадлагажигчийн өдөр тутмын ажил, байр орон сууц, эрүүл мэнд ямар байгаа вэ? (Хэт олон цагаар ажиллаж байна уу?)
- Хийх ажлынхаа талаар сургалтад явж байгаа юу, зохих мэргэжлийг эзэмшсэн үү?
- Ажлыг зохих журмын дагуу аюулгүй нөхцөлд явагдуулдаг уу? Дадлагажигч ажил дээрээ бэртэж гэмтэж байсан уу?
- Ажлыг аюулгүй нөхцөлд хийх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг байнга бэлэн байлгадаг уу?

- Дадлагажигч ажлын зориулалтын хувцас өмсдөг үү? Өмсдөг хувцас нь ажилд нь тээр болдог уу?
- Дадлагажигч нь сургагчийн өгсөн зааварчилгаа, тайлбарыг ойлгохгүй байх үе гардаг уу?

IV


Matters that Should be Considered
by Supervising Organizations

Машин техниктэй харьцах, металл боловсруулах ажилд тохиолдох осол

Тус хэсэгт техникийн дадлагажигчид машин техниктэй харьцах, металл боловсруулах ажил хийх явцад тохиолдсон бодит жишээнүүдийг харуулав.

Жишээ 1

Техникийн дадлагажигч шахагч машин дээр нэмэлт эд анги суулгаж байхдаа гишгүүр дээр санамсаргүй даржээ. Улмаар зүүн гар нь машинд тээглэж гэмтсэн байна.



Боломжит шалтгаанууд	Арга хэмжээ
Аюулгүй байдал ба эрүүл ахуйн тогтооллын 131-р зүйл, (2) дахь хэсэгт зааснаар шахагч машин дээр металл хэвлэх эд анги суулгах бол гулсуурыг шахагч дээр гэнэт буухаас сэргийлэхийн тулд хамгаалалтын блок ашиглах шаардлагатай.	Дадлагажигчдад металл хэвлэх эд анги суулгахдаа хамгаалалтын блок бэхлэгдсэн эсэхийг шалгахыг зааж өг. Мөн шалгах хуудас гаргаж ажлын журамд бичиж оруулан, шалгах хуудсыг бүрэн гүйцэт даган мөрдөх шаардлагатай.
Ажлын журамд металл хэвлэх эд анги суулгахад гишгүүр дээр эс дарах тухай зааварчилгааг дадлагажигчдад хангалттай сайн тайлбарлаж өгөөгүй байжээ.	Металл хэвлэх эд анги суулгахад анхаарал болгоомжтой байх талаар ажлын журамд дэлгэрэнгүй тайлбарлсан байх ёстой.
Дадлагажигч металл хэвлэх эд ангийг ердийн журмын дагуу суулгасаар ажлын дадалтай болсон тул жаахан хайнга ханджээ.	


[Шахагч машин дээр ажиллахад анхаарах зүйлс]

Ажлын байранд гардаг ослуудын ихэнх нь “Объект дотор эсвэл хоёр объектын завсар тээглэсэн” осол байдаг. Ийм ослоос урьдчилан сэргийлэхийн тулд хамгаалалтын төхөөрөмж суурьлуулдаг. Гэсэн хэдий ч ийм төхөөрөмжийг санамсаргүй унтраасны улмаас ажиллахгүй зогссон тохиолдлууд гарсан. Суурьлуулсан хамгаалалтын төхөөрөмжийн хэвийн ажиллагааг тогтмол шалгаж ямар нэгэн дефект байвал засвар үйлчилгээ нэн даруй хийх шаардлагатай.

Шахагч машин дээр металл хэвлэх эд анги суулгах ажил нь Аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтоолын 36-р зүйльд зааснаар аюултай ажилд тооцогддог учраас ийм ажил хийдэг дадлагажигчид тусгай сургалтад явах шаардлагатай (6-р хуудсыг хар).

Жишээ 2

Дадлагажигч зүсэж зорох суурь машин дээр ажиллаж дуусаад унтраах товчлуурыг дарж машиныг цахилгаан тэжээлээс салгажээ. Тэгээд машины ирийг засахын тулд баруун гараараа гуурсан хоолойг салгахдаа тоормос татахаа мартсан тул бээлий нь инерцтэй эргэлдэж буй ирт тээглэн баруун гарын хуруунуудыг гэмтээсэн байна.



Боломжит шалтгаанууд	Арга хэмжээ
Аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтоолын 108 дугаар зүйлд зааснаар машин техникийн ирд засвар үйлчилгээ хийхийн өмнө машин бүрэн унтарч, эд ангиуд хөдөлгөөнгүй болсон эсэхийг шалгах ёстой. Дээрх тохиолдолд ийм арга хэмжээ аваагүй учир нь техникийн дадлагажигч машиныг унтраасан боловч инерцтэй эргэлдэж буй ирд санамсаргүй гараа хүргэжээ.	Зүсэж зорох суурь машинд засвар үйлчилгээ хийхдээ машин бүрэн зогсож ир нь эргэлдэхээ больсныг шалгах тухайд ажлын журамд тодорхой зааж өгсөн байх шаардлагатай.
Дээрх тохиолдолд техникийн дадлагажигчид инерцийн эргэлтийн аюулын талаар сайн тайлбарлаж өгөөгүй байжээ.	
Мөн зүсэж зорох суурь машин дээр ажиллахдаа бээлий өмсөж болохгүй гэдгийг түүнд сайн тайлбарлаж өгөөгүй байжээ.	Бүх ажилчдад ямар хувцас өмсөх, ямар байрлалд ажиллах талаар уулзалтын үеэр, эсвэл ажил эхлэхийн өмнө сайн зааж өгөх хэрэгтэй.

[Зүсэж зорох суурь машин дээр ажиллахад анхаарах зүйлс]

Бээлий өмсөх нь гар хуруугаа бэртэж гэмтээхээс хамгаалдаг. Гэсэн хэдий ч зарим машин дээр бээлий өмсөж ажиллах нь бээлий эд ангид тээглэн, татагдаж гар хуруу бэртэх аюултай.

Тиймээс тухайн ажлын төрөл, машины төрлийг харгалзан бээлий өмсөх шаардлагатай эсэхийг тодорхойлох нь зүйтэй юм.

Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага оффис / бүс нутгийн оффис
болон салбар нэгжийн хаяг

Оффисын нэр	Засаг захиргаа	Шуудангийн код	Хаяг	Утас
Төв оффис	—	108-0022	LOOP-X 3F, 3-9-15, Kaigan, Minato-ku, Tokyo	03-6712-1523 (Төв операторын дугаар) 03-3453-8000 (Дуудлагын төв)
Саппоро оффис	Hokkaido	060-0034	Maruito Kita4-jo Bldg. 5F, 2-8-2 Kita4-johigashi, Chuo-ku, Sapporo-shi, Hokkaido	011-596-6445 (Удирдамжийн хэлтэс)
Сендай оффис	Aomori, Iwate, Miyagi, Akita, Yamagata, Fukushima	980-0803	Sendai Fukoku Seimei Bldg. 6F, 1-2-1 Kokubuncho, Aoba-ku, Sendai-shi, Miyagi	022-398-6126 (Удирдамжийн хэлтэс)
Токио оффис	Tochigi, Gunma, Saitama, Chiba, Tokyo, Kanagawa, Yamanashi	101-0041	Urban Center Kanda Sudacho 4F, 2-7-2 Kandasudacho, Chiyoda-ku, Tokyo	03-6433-9971 (Удирдамжийн хэлтэс)
Мито салбар	Ibaraki	310-0062	Asahi Seimei Mito Bldg. 2F, 1-2-40 Omachi, Mito-shi, Ibaraki	029-350-8856 (Удирдамжийн хэлтэс)
Нагано салбар	Niigata, Nagano	380-0825	Nakajima Kaikan Bldg. 6F, 1361 Suehirocho, Minaminagano, Nagano-shi, Nagano	026-217-3556 (Төв операторын дугаар)
Нагояа оффис	Shizuoka, Gifu, Aichi, Mie	460-0008	Nikken/Sumisei Bldg. 5F, 4-15-32 Sakae, Naka-ku, Nagoya-shi, Aichi	052-684-8412 (Удирдамжийн хэлтэс)
Тояама салбар	Toyama, Ishikawa, Fukui	930-0004	Toyama Kogin Bldg. 11F, 5-13 Sakurabashidori, Toyama-shi, Toyama	076-481-7560 (Удирдамжийн хэлтэс)
Осака оффис	Shiga, Kyoto, Osaka, Hyogo, Nara, Wakayama	541-0043	Osaka Asahi Seimei Bldg. 4F, 4-2-16 Koraibashi, Chuo-ku, Osaka-shi, Osaka	06-6210-3722 (Удирдамжийн хэлтэс)
Хирошима оффис	Tottori, Shimane, Okayama, Hiroshima, Yamaguchi	730-0051	Hiroshima Rijodori Bldg. 3F, 3-1-9 Otemachi, Naka-ku, Hiroshima-shi, Hiroshima	082-207-3126 (Удирдамжийн хэлтэс)
Такамацу оффис	Tokushima, Kagawa	760-0023	Takamatsu Kotobukicho Prime Bldg. 7F, 2-2-10 Kotobukicho, Takamatsu-shi, Kagawa	087-802-5850 (Төв операторын дугаар)
Мацуяама салбар	Ehime, Kochi	790-0003	Gibraltar Seimei Matsuyama Bldg. 2F, 7-1-21 Sanbancho, Matsuyama-shi, Ehime	089-909-4110 (Төв операторын дугаар)
Фукуока оффис	Fukuoka, Saga, Nagasaki, Oita, Okinawa	812-0029	Nikkan Kogyo Shinbun Seibu Branch Bldg. 5F, 1-1 Komondomachi, Hakata-ku, Fukuoka-shi, Fukuoka	092-710-4083 (Удирдамжийн хэлтэс)
Кумамото салбар	Kumamoto, Miyazaki, Kagoshima	860-0806	MY Kumamoto Bldg. 8F, 1-7 Hanabatacho, Chuo-ku, Kumamoto-shi, Kumamoto	096-223-6470 (Удирдамжийн хэлтэс)

Техникийн дадлагажигчдын аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний гарын авлага
<Машин техниктэй харьцах, металл боловсруулах ажил> Монгол хувилбар

2025 оны 3-р сард нийтлэв

Бүтээсэн, нийтэлсэн: Organization for Technical Intern Training
LOOP-X 3F, 3-9-15, Kaigan, Minato-ku, Tokyo, 108-0022
Website <https://www.otit.go.jp/>

Орчуулсан, хянан засварласан: Torindo Co., Ltd.
6F PMO Tamachi, 5-31-17 Shiba, Minato-ku, Tokyo 108-0014
Website <https://torindo.ne.jp>

Тус гарын авлагыг 2024 оны 10-р сард хүчин төгөлдөр байсан хууль тогтоомж дээр үндэслэн нийтлэв.
